

ГЕРМАНЧУУД БИДНИЙ ТУХАЙ

Монголын стратегийн байрлал – түүхэн орчин ба өнөөгийн нөхцөл байдал

*МУИС-ийн зочин профессор,
доктор Удо Б. Баркманн*

Нью-Йоркод болсон террорист халдлагын нөлөөгөөр сүүлийн үед монголын хэвлэлүүдэд Монгол Улсын геополитикийн болон стратегийн байрлалын тухай, даяаршлагад буй дэлхий дахинд Монгол Улсын явуулж буй гадаад бодлогын тухай¹, Монгол Улсын хөгжилд гуравдахь хүчнийг² /эдийн засаг³, улс төр - цэргийн⁴ хувьд/ ашиглах, өр үндэсний аюулгүй байдалд заналхийлж байгаа тухай⁵, улс орны хөгжлийн стратеги⁶, эх оронч үзлийн ач холбогдлын

¹ *Н. Баяртсайхан*, Даяаршлын ертөнц дэх Монгол Улс, Зууны Мэдээ, 30.10.2001; *С. Гомбосурэн*, Олон тулгуурт гадаад бодлого - үндэсний аюулгүй байдалын чухал хүчин зүйл, Зууны Мэдээ, 15.12.2001; *Б. Сэргэлэн*, Гадаад бодлогодоо алдаа гаргачихгүй байх нь Монголын ирээдүйд хэрэгтэй, Зууны Мэдээ, 22.01.2002.

² *Д. Оюунцэцэг*, Монголын ирээдүйн түншүүд хэн бэ?, Өдрийн Сонин, 22.05.2002.

³ Япон бол Монгол улсын импортын гуравдагч түнш, Зууны Мэдээ, 23.02.2002.

⁴ *Ж. Чойнхор*, АНУ бол манай стратегийн гуравдагч түнш, Зууны Мэдээ, 26.01.2002.

⁵ *Б. Батбилэг*, Монгол Улсын гадаад өрийг төр засаг, монголчууд төлж таарна, Зууны Мэдээ, 29.01.2002; *Ч. Улаан*, Монгол Улс ба гадаадын зээл тусламж, Үнэн, 08.02.2002; *С. Оюун*, Монгол Улс Аргентин улс шиг болох нь уу?, Өдрийн сонин, 12.02.2002; Өрийг улс төржүүлэх нь үндэсний аюулгүй байдалд санаатай учруулж буй хохирол юм, Зууны мэдээ, 26.04.2002.

⁶ *Л. Энхтайван*, *Х. Баатар*, Монгол улсад хөгжлийн стратеги бий юу? Зууны Мэдээ, 30.04.1999; *Н. Энхбаяр*, Монгол Улс хөгжих тусам тусгаар тогтнол нь баталгаажна. Зууны Мэдээ, 26.07.2001.

тухай⁷, гадаад бодлогын уламжлалт, нэгдмэл чанар⁸, Монгол Улсыг бүсийн интеграцчилалд татан оролцуулах тухай⁹ болон үндэсний аюулгүй байдлын талаар¹⁰ өгүүлсэн олон олон өгүүлэлүүд шил шилээ даран нийтлэгдэх болжээ.

2002 оны эхээр Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ хууль болон үндэсний аюулгүй байдал баталгаажих нөхцлүүдийг батлан гаргасан¹¹ бөгөөд уг хууль нь “Зэвсэгт хүчний тухай” зэрэг бусад хуулиудтай нягт холбоотой юм.¹²

Дээр дурдсан сэдвүүд нь шинэ зууны шинэ нөхцөлд Монгол Улсын оршин тогтнох чадвартай холбогдох асуудлуудыг мөн монголын стратегийн байдал, түүнд нөлөөлж буй геополитикийн нөхцөл байдлыг хөндөж байгаа юм. Түүхийн хуудсыг эргэн нэг сөхөж, тулгарч байсан бүхий л асуудлыг нягталж үзсэн хэн бүхэн Гадаад Монголын стратегийн ач холбогдол нь Орос, Хятад хоёрын дунд орших газар зүйн онцгой байрлалын улмаас хэдэн зууны туршид тун бага оорчлогдсөнийг нэн хялбархан тогтоох болно.

1. Хятадын төрийн болон Хятадын төв үзэх үзлийн төрийн номлолын үүднээс Чин улсын үед Гадаад Монгол нь 1900-аад оныг хүртэл Чин улсыг Оросоос тусгаарлах цэргийн буферийн үүргийг гүйцэтгэж байв. Гадаад Монголын энэ статусыг Орос ч мөн хүлээн зөвшөөрөхөд бэлэн байсан. Учир нь Орос Сибирийг хараахан колоничлолдоо оруулж дуусаагүй байсан бөгөөд мөн Чин улсын хил хязгаарыг хүлээн зөвшөөрснөөр Сибирийн дотоод хэрэгт Хятадын нөлөөг оруулахгүй байж чадах байлаа.

⁷ Л. Түдэв, Даяаршил ба эх оронч үзлийн үндэсний дианетика, Зууны Мэдээ, 16.10.2001; Д. Хурэлбаатар, Эх оронч үзэлгүй хүн дэлхийг яаж хайрлах юм бэ? Үнэн, 18.10.2001.

⁸ Д. Цолмон, Гадаад бодлогын уламжлалт, нэгдмэл чанарын тухай өгүүлэх нь, Өнөөдөр, 27.10.2000.

⁹ Б. Баабар, Зүүн Хойд Ази ба Монгол, Зууны Мэдээ, 08.09.2001.

¹⁰ Б. Лигдэн, Үл эвлэрэл нь үндэсний аюулгүй байдлын эмзэг өнцөг болоод байна, Зууны Мэдээ, 29.05.2002;

¹¹ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Зууны Мэдээ, 08.06.2002.

¹² Монгол Улсын Хууль, Зэвсэгт хүчний тухай, Зууны Мэдээ, 21.06.2002.

2. Хятад *Шинэ засгийн* бодлогын хүрээнд 1901 оноос Гадаад Монголыг Эзэнт их гүрнийхээ нэгэн муж болгон интеграцчилах, Оросын хилийн дагууд цэргийн ангиудыг байгуулах ажлаа эхэлсэн нь Оросын аюулгүй байдлын ашиг сонирхлыг нэн их хөндсөн ажээ. Оросын Европ дахь хэсгийг Алс дорнодын хэсэгтэй холбохын хамт Хятад - Оросын хилийн шугамын дагуу явж өнгөрөх Транссибирийн төмөр замыг барьснаар Орос стратегийн ач холбогдол бүхий зам харилцааг бий болгосон. Орос Зүүн Хятадын төмөр замыг барьснаар Хойд Манжуурт өөрийн эзэмшил газартай болсон бөгөөд уг эзэмшил газар нь Орос урт удаан хугацааны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх явцад Манжуурт нэвтрэх таатай боломжийг бүрдүүлэх үүрэгтэй байв. Орос-монголын хэлэлцээр /1912/, Орос - монгол - хятад гурван этгээдийн Хиагтын гэрээг /1915/ байгуулсан явдлыг ч мөн үүнтэй холбож үзэхээс аргагүй.

3. Зөвлөлт Орос буюу ЗХУ нь зөвлөлт засгийг бэхжүүлэхийн тулд Гадаад Монголыг Хятадын эсрэг цэргийн буфер болгон ашиглах шаардлагатай болсон. Гэвч ЗХУ нь үзэл суртлын үндэс бүхий дэлхийн хэмжээний ашиг сонирхлыг агуулж байв. ЗХУ Хятадад улс төрийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийн тулд Гадаад Монголыг өөрийн нэгэн адил улс төрийн системтэй болгож улмаар өөртэйгээ холбож өгөхийг эрмэлзсэн юм. Үүнийг хэрэгжүүлэхэд Монголын үндэсний улс оршин тогтнож байх шаардлагатай байсан бөгөөд Монгол Улсын хувьд олон улсын эрх зүйн орчинг 1924 оны 5 дугаар сарын 31-нд байгуулсан Орос - хятадын хэлэлцээр 1945 он хүртэл тодорхойлж байлаа. Зөвхөн эрх зүйн тухайн энэ орчинд л монголчууд бие даасан үндэсний төр улс болох гэсэн зүй ёсны хүсэл эрмэлзлээ биелүүлэх шаардлагатай болсон. Гэвч энэ орчин нь монголчууд үндэснийхээ ашиг сонирхолд үйлчлэх гадаад бодлогыг явуулах боломжийг 1949 он хүртэл үнэндээ огт олгоогүй юм. ЗХУ батлан хамгаалах номлолдоо БНМАУ-ыг цэргийн буфер гэж цаашид ч мөн үзэж байсан учраас Монголыг Зөвлөлдүүдийнхээ Холбоонд ЗСБНУ болгон нэгтгэх талаар хэзээ ч санаархаж байсангүй.¹³

¹³ cf. Udo B. Barkmann, *Geschichte der Mongolei*, Bonn 1999, 422 S.

4. 1949 онд БНХАУ олон улсын эрх зүйн үүднээс Монгол Улсыг хүлээн зөвшөөрснөөр чанарын маш том өөрчлөлт гарсан. Монгол Улс олон улсын эрх зүйн субъект болсон. Хятад социалист чиг баримжааг сонгож, социалист орнуудын хамтлаг байгуулагдан, БНМАУ-ыг НҮБ-д гишүүнээр авсан зэрэг нь Монгол Улс гадаад бодлого хүрээгээ тэлж, үндэсний ашиг сонирхлоо илүүтэйгээр харгалзан үзэх боломжийг олгосон юм. Үзэл суртлын ялгаатай байдлын улмаас Москва, Бээжингийн харилцаа муудаж, улам даамжрах үед ЗСБНХУ батлан хамгаалах номлолынхоо хүрээнд Хятадын эсрэг цэргийн буферийн үүргийг Монголд дахин хүлээлгэсэн.¹⁴ Энэ үүргийнхээ ачаар БНМАУ нь ЗСБНХУ болон ЭЗХТЗ-ийн тусламжтайгаар эдийн засгийн ихээхэн ахиц дэвшилд хүрсэн юм.

Дүгнэлт 1691 - 1989 он: – Өнгөрөгч бүхий л хугацаанд Гадаад Монгол /БНМАУ/ нь Хятадын эсвэл Оросын /ЗСБНХУ/ цэргийн буферийн үүргийг гүйцэтгэсээр ирсэн. Чин улсын бүрэлдэхүүн хэсэг байх үед нь Гадаад Монголд буферийн үүргийг Хятад оноож байсан бол Монголын хувьд тодорхой хэмжээгээр арай бие даасан боловч түүний хяналтан дор байх буферийг Орос илүү сонирхож байв.

Социалист систем задран унаснаар Монгол үндэсний улс элдэв хараа хяналтнаас ангижирч бүрэн бие даасан улс болсон. Монгол Улс олон улсын харилцааны субъект болов. Монгол улс олон улсын чухал чухал байгууллагуудад гишүүнээр элсэн, олон талт гадаад харилцааг хөгжүүлэхийн хамт зөвхөн Орос, Хятадтай л харилцдаг байсан тэр хүрээнээсээ анх удаа бүрэн гарч чадсан юм. Хэдийгээр Монгол Улс түүхэн туршлагынхаа үүднээс хоёр хөршийнхээ аль нэгийг илүүд үзэх буюу аль нэг талыг илүү давамгайлсан байдалд оруулахыг хүсдэггүй боловч Монгол Улс өөрийн газар зүйн байрлалын онцлогийг харгалзан үзэж “Монгол улсын гадаад бодлогын

¹⁴ cf. *Udo B. Barkmann, Die mongolisch-chinesischen Beziehungen (1955-1996) - eine Anamnese, in Mitteilungen des Institutes für Asienkunde Hamburg, Hamburg 2000, 180 S.*

үзэл баримтлал"-даа /1994/ Орос, Хятадтай харилцах харилцааг гадаад бодлогын тэргүүлэх чиглэл хэмээн тодорхойлсон. Нэг талаар Оросын өнөөгийн сул дорой байдал, нөгөө талаас Хятадын хүчирхэг байдлын улмаас Монгол Улс олон улсын янз бүрийн гэрээ хэлэлцээрийн механизмд нэгдэн орж, Япон, АНУ, Европ зэрэг бүс нутаг болон улс орнуудтай идэвхтэй харилцсанаар л Монгол Улс дээр дурдсан зарчмуудыг тодорхой хэмжээгээр биелүүлэх боломжтой.

Монгол Улс нь Оросын хувьд ч гэсэн Хятадын хувьд ч гэсэн аюулгүй байдлын бодлогын үүднээс өөрийн ач холбогдлоо сүүлийн үед ч гэсэн огт алдаагүйг дурдалгүй өнгөрч болохгүй юм. Орос - монголын хил "Энх тайван, хамтын ажиллагааны хил" хэвээр үлдэх ёстой хэмээн сүүлийн үед Оросын тал олонтаа онцлон тэмдэглэсэн нь санамсаргүй хэрэг биш юм.¹⁵ Өмнөд Сибирьт хятадууд цагаачлан ирж буй нь өнөөгийн Орос-хятадын сайн харилцааны улмаас шийдвэрлэх арга зам үгүй мэт санагдаж буй боловч түүнээс удаан хугацааны дараа илрэн гарах үр дагаврыг Гадаад хэргийн сайд Иванов болон Оросын улс төрчид анхааралдаа авах болов уу. Харин Хятад одоо барих гэж буй байгалийн хийн хоолойг монголын нутгаар дайран өнгөрүүлээгүй нь эдийн засгийн төдийгүй аюулгүй байдлын учир шалтгаантай хэмээн тайлбарлаж байна.

Хүчээ авч буй даяаршлалын үйл явцын хүрээнд дэлхий нийтээр улс хоорондын харилцаа нь эдийн засагт илүү тулгуурлах хандлагатай болж буй нь сүүлийн арван жилийн хугацаанд ажиглагдаж байна.

Монголын улс төрчид сүүлийн арван жилийн хугацаанд гадаадаас орж ирэх хөгжлийн тусламжинд найдах болжээ. Япон улсын үүсгэн санаачилсан хандивлагчдын чуулга уулзалт ихээхэн хэмжээний зээл, тусламжийг Монголд үзүүлж, үнэндээ монголын хөгжлийг дэмжсээр ирсэн. 1991 оноос хойш Монгол Улсад 2,9 млрд. ам.долларын зээл тусламжийг хандивлагчдын зүгээс олгоод байна. Өнөөг хүртэл ашиглаад байгаа 2,1 млрд

¹⁵ Ch. Sumya, Russo - Mongolian Relations Crystallize, in The UB Post, 08.11.2001.

ам.долларын 1,2 млрд. нь хөнгөлөлттэй зээл байв. Ингэснээр монголын өр дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ -ний 80 орчим хувьд хүрээд байна. Ер нь аливаа улсын өр ДНБ-нийхээ 60 хувиас давсан үед улс орны тусгаар тогтнолд ноштой аюул тулгарч, тухайн улс олон улсын харилцааны субъектын үүргийг гүйцэтгэх боломжоо алдаж, зээл авагч объект болж хувирна гэж ярьдаг.¹⁶ Үндэсний улсын хүч чадавхийг уламжлалт хэмжүүрээр тодорхойлбол нийт байдал мөн л сөрөг дүнтэй гарч байна. Байгалийн нөөц /металл болон металл биш түүхий эд/, сэргээгдэхгүй эрчим хүч /чулуун нүүрс, нефть, уран/ болон газрын нөөц баялаг зэрэг багтах геопотенциалийг ашиглах явдал л Монгол Улсын хувьд арай бодитой боломж болох юм. Монгол зэрэг орнууд ойролцоогоор 30 - 40 жилийн дараа дэлхий нийтийн түгээмэл уламжлалт уул уурхайн үйлдвэрүүдэд түүхий эдийг олборлосоор түүний нөөц шавхагдах тийшээ хандах үед тодорхой хэмжээний “хүч чадавхитай” болсон байх болно. Түүхий эд хэнд байна тэр хүч чадавхитай байх албагүй бөгөөд харин энэ нь түүхий эдийн байрлалыг тогтоох, нээх, бүрэн дүүрэн олборлох санхүүгийн болон техникийн боломжтой эсэхээс мөн хамаардагийг дурдалгүй өнгөрч болохгүй юм.¹⁷ Сүүлийн жилүүдэд тухайлбал 1999 онд Япон, Хятад, Өмнөд Солонгосын төр засгийн тэргүүн нар Монголд айлчлах үеэр Монгол Улсын түүхий эдийг боловсруулахад эдгээр орнуудын техник, технологийн боломжийг ашиглах тухайд тодорхой тодорхой саналуудыг Монгол Улс хүлээн аваад байна. Эдгээр улс орнууд Монгол Улстай “иж бүрэн түншлэл”-ийн харилцааг тодруулбал “харилцан ашигтай байх” хамтын ажиллагааг хөгжүүлэхээр зорьж буй нь тохиолдлын хэрэг биш юм. Япон, Өмнөд

¹⁶ Б. Батбилэг, Түүхийн сүүдэр, Монголын хувьд гадаадын зээл, тусламжийг хүртэх нь бахархалтай гэхээсээ хаширмаар явдал юм, Зууны Мэдээ, 21.05.2002.

¹⁷ Зууны Мэдээ, 02.06.1999; К.Обучи Япон улс Монголыг үргэлжлүүлэн дэмжинэ гэдгийг гадаад, дотоодод илэрхийлнэ, Өдрийн Сонин, 14.07.1999; БНХАУ-ын дарга Зянь Земинь Монголын хэвлэлд ярилцлага өглөө, Өдрийн Сонин, 14.07.1999.

Солонгос, Хятад газрын баялаг багатай төдийгүй түүхийн эдийн хэрэгцээ тэнд өссөөр байна. Зүүн хойд Азийн интеграцчиллын /Орос улсыг оруулаад/ үйл явцад оролцогч бүх талуудын хүсэл эрмэлзлийг хэрэгжүүлэх нь Америкийн нөлөө зонхилж буй даяаршлалаас Зүүн Хойд Азийг цаашид тодорхой хэмжээгээр бие даасан байдалд хүргэх боломжтой. Монгол Улс жишээлбэл хөрш орнуудынхаа геопотенциалд тодорхой анализ хийж Монгол Улс өөртөө буй боломжийг нээж болно. Хятадад ч гэсэн ОХУ-ын өмнөд Сибирийн бүсэд ч гэсэн хүнсний зүйлсийн нөөц хязгаарлагдмал байна. Монгол Улс бүсийнхээ хамгийн том мах үйлдвэрлэгч, нийлүүлэгч ч байж магадгүй юм.

Нэн тэргүүнд Монгол Улс бүсийн хамтын ажиллагаанд оролцох нь Монгол Улсад хөгжлийн боломжуудыг олгох юм. Хэрвээ Монгол Улс бүс нутгийнхаа зохистой үйл ажиллагаанд илүү идэвхи санаачлагатай оролцох аваас эдгээр боломжийг нэмэгдүүлэх бололцоотой юм. Ихэвчлэн компромис хийх болдог том орнуудыг бодвол жижиг орнууд гадаад бодлогын идэвхтэй үйл ажиллагааныхаа дүнд илүү амжилт олдог тухай Нидерланд зэрэг жижиг орнуудын туршлага бас бий. Иймд Монгол Улсын газар зүйн байрлалын улмаас бэрхшээл тохиолдсон үед байнга тусламжийн гараа сунгаж байх гурав дахь хүчний тухай болох нь Монгол Улсын хувьд илүүц зүйл ч байж магадгүй юм.